

ИМПОРТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ПРОЦЕДУРЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Гишүүд,

Олон талт худалдааны хэлэлцээрийг *анхааралдаа авч;*

1994 оны ТХЕХ-ийн зорилтыг цаашид *урагшлуулахыг эрмэлзэж;*

Хөгжиж буй гишүүн орнуудын худалдаа, хөгжил болон санхүүгийн онцгой хэрэгцээ шаардлагыг *анхааралдаа авч;*

Тодорхой зорилгод нийцсэн импортын автоматжуулсан тусгай зөвшөөрлийн ач холбогдол, мөн худалдааг хязгаарлахад тухайн тусгай зөвшөөрлийг ашиглах ёсгүйг хүлээн *зөвшөөрч,*

1994 оны ТХЕХ-ийн холбогдох заалтын дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд тусгай зөвшөөрөл ашиглаж болохыг хүлээн *зөвшөөрч,*

Импортын тусгай зөвшөөрөл олгох процедурт үйлчлэх агуулгаар нь 1994 оны ТХЕХ-ийн заалтыг хүлээн *зөвшөөрч,*

Импортын тусгай зөвшөөрөл олгох процедурыг 1994 оны ТХЕХ-ийн зарчим, үүрэгтэй харшлах хэлбэрээр хэрэгжүүлэхгүй байхыг *эрмэлзэж,*

Импортын тусгай зөвшөөрөл олгох процедурыг зохисгүй байдлаар ашиглах нь олон улсын худалдааны урсгалд саад учруулна гэдгийг хүлээн *зөвшөөрч,*

Импортын тусгай зөвшөөрөл, тухайлбал импортын автоматжуулсан бус тусгай зөвшөөрлийг ил тод, урьдчилан харах боломжтой байдлаар хэрэгжүүлэх нь зүйтэй гэдэгт *итгэж,*

Импортын автоматжуулсан бус тусгай зөвшөөрөл олгох процедур нь зайлшгүй шаардлагатай арга хэмжээнээс илүү хүнд суртал учруулах ёсгүй гэдгийг хүлээн *зөвшөөрч,*

Олон улсын худалдаанд хэрэглэгддэг захиргааны процедур болон практикийг хялбарчлах, ил тод байлгах, ийм процедур, практикийг шударга, ижил тэгш хэлбэрээр хэрэгжүүлж, зохицуулахыг *эрмэлзэж,*

Энэхүү Хэлэлцээрийн тухайд үүсэж болох маргааны асуудлаар зөвлөлдөх механизм бий болгох, маргааныг шуурхай, үр дүнтэй, эрх тэгш байдлаар шийдвэрлэж байхыг *эрмэлзэж,*

Үүгээр дараах зүйлийг хэлэлцэн тохиров.

1 дүгээр зүйл *Нийтлэг заалт*

1. Энэхүү Хэлэлцээрээр импортын тусгай зөвшөөрөл гэдгийг импортлогч гишүүн орны гаалийн нутаг дэвсгэрт импорт хийхээс өмнө холбогдох захиргааны байгууллагад өргөдөл, эсхүл бусад бичиг баримт (гаалийн зорилгоор шаардсанаас бусад тохиолдол)

ирүүлэхийг шаарддаг импортын тусгай зөвшөөрлийн дэглэмийг хэрэгжүүлэхэд ашиглагдаж буй захиргааны процедур¹ гэж тодорхойлно.

2. Хөгжиж буй гишүүн орнуудын эдийн засгийн хөгжлийн зорилт болон санхүү, худалдааны хэрэгцээг харгалзан үзэж, тухайн процедурыг зохисгүй байдлаар хэрэгжүүлсний улмаас худалдаанд гажуудал үүсэхээс урьдчилан сэргийлэхийн сацуу импортын тусгай зөвшөөрлийн дэглэмийг хэрэгжүүлэхэд ашиглах захиргааны процедурыг 1994 оны ТХЕХ, түүний хавсралт, протоколуудын холбогдох заалтуудтай нийцүүлсэн байх явдлыг гишүүд хариуцна.²

3. Импортын тусгай зөвшөөрөл олгох процедурын журмыг шударга, эрх тэгш зарчмаар ашиглах, хэрэгжүүлэхдээ аль нэг талыг барьсан байх ёсгүй.

4. (a) Өргөдөл гаргахтай холбоотой процедурын журам болон бүхий л мэдээлэл, түүний дотор өргөдөл гаргах эрх бүхий хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага, өргөдөл хүлээн авах захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл шаардлагатай барааны жагсаалтыг хэвлэн нийтэлж, 4 дүгээр зүйлд заасан Импортын тусгай зөвшөөрлийн хороо (цаашид энэхүү Хэлэлцээрт “Хороо” гэх)-нд мэдэгдсэнээр засгийн газрууд³ болон худалдаа эрхлэгчид танилцах боломжтой болно. Чингэхдээ, дээр дурдсан мэдээллийг тусгай зөвшөөрлийн шаардлагыг хэрэгжүүлж эхлэхээс 21 өдрийн өмнө, эсхүл боломжит хугацаанд, гэхдээ аль ч тохиолдолд шаардлагыг хэрэгжүүлж эхлэх өдрөөс өмнө хэвлэн нийтэлнэ. Импортын тусгай зөвшөөрөл олгох процедур, эсхүл импортын тусгай зөвшөөрөл шаардлагатай барааны жагсаалтад ямар нэг хасалт хийх, цуцлах, өөрчлөлт хийх тохиолдол гарсан бол энэ талаар дээр дурдсантай ижил байдлаар, ижил хугацаанд багтаан хэвлэн нийтлэх ёстой. Эдгээр нийтлэлийн хувийг Нарийн бичгийн дарга нарын газарт мөн хүргүүлсэн байна;

(b) Бичгээр тайлбар хийхийг хүссэн гишүүдэд тухайн тайлбараа хүсэлт гарвал хэлэлцүүлэх боломж олгоно. Холбогдох гишүүн эдгээр тайлбар, хэлэлцүүлгийн үр дүнг анхааран авч үзвэл зохино.

5. Өргөдлийн маягт болон шаардлагатай тохиолдолд шинэчлэх маягт нь аль болох энгийн байна. Гагцхүү тусгай зөвшөөрөл олгох хэвийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бичиг баримт, мэдээллийг өргөдөл гаргахад шаардаж болно.

6. Өргөдөл гаргах процедур болон шаардлагатай тохиолдолд шинэчлэх процедур нь аль болох энгийн байна. Тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргах боломжит хугацааг өргөдөл гаргагчид олгоно. Өргөдөл хүлээн авах хугацаа заасан бол энэ хугацаа нь хамгийн багадаа 21 өдөр байх бөгөөд энэ хугацаанд хангалттай тооны өргөдөл хүлээж аваагүй нөхцөлд хугацааг сунгах боломжтой байна. Өргөдөл гаргагч нь зөвхөн нэг захиргааны байгууллагад өргөдөлтэй холбогдуулан хандах ёстой. Хэрэв өргөдөл гаргагч нэгээс илүү захиргааны байгууллагад зайлшгүй хандах шаардлага гарвал гурваас дээш байгууллагад хандах ёсгүй.

7. Агуулгыг бүрдүүлж буй үндсэн үзүүлэлтийг өөрчлөхгүй бичиг баримтын ялихгүй алдаа нь өргөдлийг буцаах үндэслэл болохгүй. Бичиг баримтын, эсхүл процедурын алдаа нь санаатайгаар залилан мэхлэх, санамсаргүй алдаа гаргаснаас бусад тохиолдолд үүссэн бол анхааруулга өгөх төдий хэмжээнээс хэтэрсэн торгууль ногдуулахгүй.

¹ “Тусгай зөвшөөрөл олгох” гэж тодорхойлсон процедурууд, мөн ижил төстэй захиргааны бусад процедур

² Тусгай зөвшөөрлийн процедураар хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэл, үйлчлэх хүрээ болон үргэлжлэх хугацааг энэхүү Хэлэлцээрээр эргэлзээтэй гэж үзэх байдлаар Хэлэлцээрийн аль ч заалтыг тайлбарлахгүй.

³ Энэхүү Хэлэлцээрийн зорилгоор, “засгийн газрууд” гэсэн нэр томъёонд Европын хамтын нийгэмлэгүүдийн эрх бүхий байгууллагуудыг оруулна гэж үзнэ.

8. Тээвэрлэлтийн болон бөөнөөр ачих явцад бий болсон өөрчлөлт, түүнчлэн хэвийн худалдааны практикт гардаг бусад бага хэмжээний өөрчлөлтийн улмаас тусгай зөвшөөрөлд дурдсан үнэ, тоо хэмжээ, жингийн бага зэргийн зөрүү нь тусгай зөвшөөрөлтэй импортоос татгалзах үндэслэл болохгүй.

9. Тусгай зөвшөөрөлтэй импортын төлбөр хийхэд шаардагдах гадаад валютыг сольж авахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь импортын тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй бараа импортлогчтой ижил нөхцөл эдэлнэ.

10. Аюулгүй байдалд хамаарах үл хэрэглэх заалтын хувьд 1994 оны ТХЕХ-ийн 21 дүгээр зүйлийн заалт үйлчилнэ.

11. Энэхүү Хэлэлцээрийн заалтууд нь хууль сахиулах үйл ажиллагаанд саад учруулах, эсхүл нийтийн эрх ашигт үл нийцэх, эсхүл хувийн, төрийн тодорхой аж ахуйн нэгж, байгууллагын хууль ёсны арилжааны ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй нууцалбал зохих мэдээллийг задлахыг аливаа гишүүнээс шаардахгүй.

2 дугаар зүйл

Импортын автоматжуулсан тусгай зөвшөөрөл⁴

1. Импортын автоматжуулсан тусгай зөвшөөрөл гэж гаргасан өргөдөлд ямар ч тохиолдолд зөвшөөрөл олгодог, 2(a) хэсгийн шаардлагад нийцсэн импортын тусгай зөвшөөрлийг хэлнэ.

2. Импортын автоматжуулсан тусгай зөвшөөрөл олгоход 1 дүгээр зүйлийн 1-11 дэх хэсгүүд болон энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудаас гадна дараах зүйлийг⁵ баримтална:

(a) Импортын автоматжуулсан тусгай зөвшөөрөл олгох процедур нь автоматжуулсан тусгай зөвшөөрөлд хамрагдах импортыг хязгаарлах нөлөөтэй байхаар үйлчлэх ёсгүй. Импортын автоматжуулсан тусгай зөвшөөрөл олгох процедур нь дараах шаардлагыг биелүүлээгүй бол худалдааг хязгаарлах нөлөөтэй гэж үзнэ. Тухайлбал (*inter alia*):

(i) импортлогч гишүүн орны автоматжуулсан тусгай зөвшөөрөл олгох бараанд хамаарах импортын үйл ажиллагаа эрхлэх хууль ёсны шаардлагыг хангаж байгаа аливаа хувь этгээд, аж ахуйн нэгж, байгууллага өргөдөл гаргах, импортын тусгай зөвшөөрөл эзэмших тэгш эрх эдлэх;

(ii) тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг бараанд гаалийн бүрдүүлэлт хийхээс өмнө ажлын аль ч өдөр гаргаж болдог байх;

(iii) зохих шаардлагын дагуу бүрэн ирүүлсэн тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг захиргааны байгууллага хүлээн авсан даруй боломжит хугацаанд, чингэхдээ ажлын 10 өдөрт багтаан баталсан байх.

(b) Холбогдох бусад процедур хэрэглэх бололцоогүй нөхцөлд импортын автоматжуулсан тусгай зөвшөөрөл шаардлагатай гэдгийг гишүүд хүлээн зөвшөөрнө. Импортын автоматжуулсан тусгай зөвшөөрөл нь түүнийг

⁴ Импортыг хязгаарлах үр дагаваргүй, дэнчин шаардсан тусгай зөвшөөрөл олгох процедур нь 1 болон 2 дахь хэсгээр зохицуулагдана гэж үзнэ.

⁵ Импортын тусгай зөвшөөрөл олгох тухай 1979 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн Хэлэлцээрт оролцогч бус бөгөөд (a)(ii) болон (a)(iii) хэсгүүдийн дагуу тавигдах шаардлагуудыг биелүүлэхэд онцын хүндрэлгүй байгаа хөгжиж буй гишүүн орны зүгээс Хороонд мэдэгдэл өгсний дараа эдгээр дэд хэсгийн заалтыг хэрэгжүүлэх явдлыг ДХБ-ын тухай Хэлэлцээр тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилээс хэтрэхгүй хугацаагаар түр хойшлуулж болно.

нэвтрүүлэхийг шаардсан нөхцлүүд давамгайлсан хэвээр байгаа болон түүнийг хэрэгжүүлэх болсон захиргааны зорилгыг өөр аргаар хэрэгжүүлэх бололцоогүй тохиолдолд ашиглагдсан хэвээр байна.

3 дугаар зүйл

Импортын автоматжуулсан бус тусгай зөвшөөрөл

1. Импортын автоматжуулсан бус тусгай зөвшөөрөл олгох процедурд 1 дүгээр зүйлийн 1-11 дэх хэсгийн заалтаас гадна дараах заалт хамаарна. Импортын автоматжуулсан бус тусгай зөвшөөрөл олгох процедурыг 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тодорхойлолтод хамаарахгүй импортын тусгай зөвшөөрөл гэж тодорхойлно.

2. Автоматжуулсан бус тусгай зөвшөөрөл нь мөрдөгдөж буй хязгаарлалт дээр нэмж худалдааг хязгаарлах, эсхүл гажуудуулах нөлөөг импортод үзүүлэх ёсгүй. Импортын автоматжуулсан бус тусгай зөвшөөрөл олгох процедур нь хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ цар хүрээ, хугацаатай уялдаатай байх бөгөөд эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай хэмжээнээс илүү захиргааны хүнд суртал үүсгэх ёсгүй.

3. Гишүүн тоо хэмжээний хязгаарлалтыг хэрэгжүүлэхээс өөр зорилгоор тусгай зөвшөөрөл олгох шаардлага байгаа тохиолдолд бусад гишүүн болон худалдаа эрхлэгчдэд зориулан тусгай зөвшөөрөл авах болон/эсхүл хуваарилах үндэслэлийг ойлгуулахад чиглэсэн хангалттай мэдээллийг хэвлэн нийтлэнэ.

4. Аливаа гишүүн нь хувь этгээд, аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрлийн шаардлагыг үл хэрэглэх, эсхүл хэсэгчлэн хэрэглэх бололцоо олгож байгаа тохиолдолд 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан нийтэлбэл зохих мэдээлэлд тусгасан байх бөгөөд тийм хүсэлтийг хэрхэн гаргах, эдгээр хүсэлтийг хүлээн авч болохуйц нөхцөл байдлын талаар бололцооны хэрээр мэдээлэл өгвөл зохино.

5. (а) Гишүүд тухайн бүтээгдэхүүний худалдаа эрхлэхийг сонирхсон аль нэг гишүүний хүсэлтийн дагуу дараах асуудлаар холбогдох бүх мэдээлэл өгнө:

(i) хязгаарлалтыг хэрэгжүүлэх захиргааны арга хэмжээ;

(ii) сүүлийн үед олгосон импортын тусгай зөвшөөрлүүд;

(iii) нийлүүлэгч орнуудад дээрх тусгай зөвшөөрлийг хуваарилсан байдал;

(iv) бололцоотой тохиолдолд импортын зөвшөөрөлд хамрагдаж буй барааны статистик мэдээ (тухайлбал, үнэ, тоо хэмжээ). Үүнтэй холбогдуулж, хөгжиж буй гишүүнд захиргааны болон санхүүгийн нэмэлт дарамт учруулахгүй байх;

(b) Тусгай зөвшөөрлөөр квот хэрэгжүүлдэг гишүүд нь квотын нийт хэмжээг тоо хэмжээ болон/эсхүл үнийн дүнгээр, түүний эхлэх болон дуусах өдөр, тэдгээрт оруулсан аливаа өөрчлөлтийн тухай мэдээллийг 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд засгийн газрууд болон худалдаа эрхлэгчид танилцах боломжтой байдлаар нийтэлнэ;

(c) Нийлүүлэгч орнуудад квот хуваарилсан тохиолдолд, хязгаарлалт тавьж буй гишүүн орон тухайн барааг нийлүүлэх сонирхолтой бусад бүх гишүүн оронд хамгийн сүүлд хуваарилсан квотын хувь, тоо хэмжээ, эсхүл үнийн дүнг нэн даруй мэдээлэх бөгөөд эдгээр мэдээллийг 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд засгийн газрууд болон худалдаа эрхлэгчид танилцах боломжтой байдлаар нийтэлнэ;

(d) Квотыг товлосноос эрт нээх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан мэдээллийг мөн хэсэгт заасан хугацаанд засгийн газрууд болон худалдаа эрхлэгчид танилцах боломжтой байдлаар нийтэлнэ;

(e) Импортлогч гишүүний хууль эрх зүйн болон захиргааны шаардлагыг биелүүлж буй аливаа хувь этгээд, аж ахуйн нэгж, байгууллага тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргах болон түүнийг авч хэлэлцэхэд тэгш хангагдана. Зөвшөөрөл хүссэн өргөдлийг батлаагүй тохиолдолд өргөдөл гаргасан этгээдэд шалтгааныг мэдэгдэх бөгөөд өргөдөл гаргасан этгээд нь импортлогч гишүүний дотоодын хууль тогтоомжийн дагуу давж заалдах, эсхүл хянуулах эрх эдлэнэ;

(f) Өргөдөл хянаж шийдвэрлэх хугацаа нь гишүүний хяналтаас гадуур шалтгаанаар бололцоогүй гэж үзсэнээс бусад тохиолдолд өргөдөл ирүүлсэн дарааллаар буюу түрүүлж ирснийг нь эхэнд авч үзэх гэсэн зарчмыг баримтлах нөхцөлд 30 хоногоос илүүгүй, бүх өргөдлийг нэгэн зэрэг хүлээн авсан гэж тооцох нөхцөлд 60 хоногоос илүүгүй байна. Сүүлчийн тохиолдолд өргөдөл хянаж шийдвэрлэх хугацааг өргөдөл хүлээх авах хугацаа дууссаны дараагийн өдрөөс эхэлсэн гэж үзнэ;

(g) Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь боломжит хугацаанд үргэлжлэх бөгөөд импортод саад учруулахаар богино байх ёсгүй. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь урьдчилан тооцоолох боломжгүй богино хугацааны шаардлагуудад нийцүүлэх импортын онцгой тохиолдлоос бусад нөхцөлд алслагдсан цэгээс ирэх импортод саад учруулах ёсгүй;

(h) Гишүүд квотыг зохицуулахдаа, олгосон тусгай зөвшөөрлийнх нь дагуу импорт хийхэд саад учруулах ёсгүй бөгөөд квот бүрэн ашиглахад хүндрэл учруулах ёсгүй;

(i) Гишүүд тусгай зөвшөөрөл олгох үедээ эдийн засгийн хувьд үндэслэлтэй тоо хэмжээгээр тухайн бараанд зөвшөөрөл олгох нь зохистой эсэхийг харгалзан үзнэ;

(j) Гишүүд тусгай зөвшөөрөл хуваарилахдаа өргөдөл гаргагчийн импортын гүйцэтгэлийг харгалзан үзнэ. Энэ тохиолдолд өргөдөл гаргагчид өнгөрсөн хугацаанд олгосон тусгай зөвшөөрлийг бүрэн дүүрэн ашигласан эсэхийг анхаарч үзнэ. Өмнө олгосон тусгай зөвшөөрлийг бүрэн ашиглаагүй тохиолдолд тухайн гишүүн чингэх болсон шалтгааныг хянаж үзэх бөгөөд шинэ тусгай зөвшөөрөл хуваарилах үедээ үүнийг харгалзан үзнэ. Мөн тусгай зөвшөөрлийг холбогдох бүтээгдэхүүнд эдийн засгийн хувьд үндэслэлтэй хэмжээгээр олгох хэрэгцээг бодолцон, шинэ импортлогчдод зохистой хуваарилах явдлыг хангана. Энэ тохиолдолд хөгжиж буй гишүүн орон, үүний дотор нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудаас гарал үүсэлтэй бүтээгдэхүүн импортлогчийг тусгайлан харгалзан үзнэ;

(k) Нийлүүлэгч орнуудад хуваарилаагүй тусгай зөвшөөрлөөр зохицуулж буй квотын тохиолдолд, тусгай зөвшөөрөл эзэмшигчид⁶ нь импортын эх үүсвэрийг чөлөөтэй сонгоно. Квотыг нийлүүлэгч орноор хуваарилсан тохиолдолд тухайн орон, бүлэг орнуудыг тусгай зөвшөөрөлд тодорхой заасан байна;

(l) 1 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийг хэрэглэхдээ, импорт нь өмнөх тусгай зөвшөөрлөөр тодорхойлсон түвшингээс илүү гарсан тохиолдолд дараа олгох тусгай зөвшөөрлийн хуваарилалтад нөхөн залруулга хийж болно.

4 дүгээр зүйл

Байгууллагууд

Гишүүн бүрийн төлөөлөгчөөс бүрдсэн Импортын тусгай зөвшөөрлийн хороог үүгээр байгуулж байна. Хороо нь дарга болон дэд дарга сонгож, энэхүү Хэлэлцээрийн үйлчлэл, эсхүл түүний зорилтыг урагшлуулах тухай аливаа асуудлаар зөвлөлдөөн хийх боломжийг олгох үүднээс шаардлагатай үед хуралдана.

⁶ Зарим үед “квот эзэмшигчид” гэдэг

5 дугаар зүйл

Мэдэгдэл

1. Тусгай зөвшөөрөл олгох процедур нэвтрүүлж байгаа, эсхүл түүнд өөрчлөлт оруулж байгаа гишүүд тэдгээрийг хэвлэн нийтлэснээс хойш 60 өдрийн дотор энэ тухай Хороонд мэдэгдэнэ.

2. Импортын тусгай зөвшөөрөл олгох процедурын тухай эрх бүхий байгууллагын мэдэгдэл нь дараахь мэдээллийг агуулсан байна:

(a) тусгай зөвшөөрөл шаардлагатай барааны жагсаалт;

(b) тусгай зөвшөөрөл олгох процедуртой холбогдсон мэдээлэл өгөх этгээд;

(c) өргөдөл хүлээн авах байгууллага;

(d) тусгай зөвшөөрөл олгох процедурыг нийтэлсэн өдөр болон хэвлэлийн нэр;

(e) 2 болон 3 дугаар зүйл дэх тодорхойлод өгсөн нэр томъёоны дагуу тусгай зөвшөөрөл олгох процедур нь автоматжуулсан, эсхүл автоматжуулсан бус эсэх тухай тодотгол;

(f) импортын автоматжуулсан тусгай зөвшөөрөл олгох процедуртой тохиолдолд тэдгээрийг хэрэглэх болсон зохицуулалтын зорилго;

(g) импортын автоматжуулсан бус тусгай зөвшөөрөл олгох процедуртой тохиолдолд тусгай зөвшөөрөл хэрэглэх журмаар хэрэгжүүлэх болсон арга хэмжээний тодотгол;

(h) хэрэв тогтоох бололцоотой бол тусгай зөвшөөрөл олгох процедурын үйлчлэхээр тооцоолж буй хугацаа, тогтоох бололцоогүй бол ийм мэдээлэл өгөх боломжгүй байгаа шалтгаан.

3. Импортын тусгай зөвшөөрөл олгох процедурд орсон өөрчлөлтийг мэдэгдэхдээ орсон өөрчлөлтийн тухайд дээр дурдсан зүйлийг мэдээлнэ.

4. Гишүүд 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт шаардсан мэдээллийг нийтлэх хэвлэлийн талаар Хороонд мэдэгдэнэ.

5. Аль нэг хүссэн гишүүн өөр нэг гишүүн нь тусгай зөвшөөрөл олгох процедурыг нэвтрүүлсэн, эсхүл түүнд өөрчлөлт оруулсан тухайгаа энэ зүйлийн 1-3 дахь хэсгийн заалтын дагуу мэдэгдээгүй гэж үзвэл энэ тухай бусад гишүүний сонорт хүргэнэ. Хэрэв үүний дараа ч холбогдох мэдэгдлийг гишүүн орон нэн даруй хийгээгүй бол тэрхүү хүссэн гишүүн өөрөө тусгай зөвшөөрөл олгох процедур, эсхүл түүнд орсон өөрчлөлтийн талаар боломжит бүх мэдээллийг хамруулан мэдэгдэл хийж болно.

6 дугаар зүйл

Зөвлөлдөх болон маргаан таслах

Энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлд нөлөө үзүүлсэн аливаа асуудлаар гарах маргааны талаар зөвлөлдөх, шийдвэр гаргахдаа 1994 оны ТХЕХ-ийн 22 болон 23 дугаар зүйлийн заалтуудыг Маргаан таслах ойлголцлын баримт бичгээр дэлгэрүүлэн тайлбарласан байдлаар нь хэрэглэнэ.

7 дугаар зүйл

Хянан үзэх

1. Хороо нь энэхүү Хэлэлцээрийн үйлчлэл болон хэрэгжилтийг түүний зорилт, түүнд дурдсан эрх, үүргийг анхааралдаа авах замаар шаардлагатай үед, чингэхдээ хоёр жилд нэгээс доошгүй удаа хянаж үзнэ.

2. Нарийн бичгийн дарга нарын газар нь 5 дугаар зүйлд заасан мэдээлэл, импортын тусгай зөвшөөрөл олгох процедурын⁷ тухай жил бүрийн судалгааны асуулгын хариулт болон бусад холбогдох баримтад тулгуурлан баримтад тайлан гаргаж, хяналт тавих үндэс болгон Хороонд өгнө. Энэхүү тайланд дээр дурдсан мэдээлэл, ялангуяа тайлант хугацаанд гарсан аливаа өөрчлөлт, үйл явдал болон Хороогоор зөвшөөрсөн бусад мэдээллийг тодотгон тойм байдлаар тусгана.

3. Гишүүд импортын тусгай зөвшөөрөл олгох процедурын тухай жил бүрийн судалгааны асуулгад шуурхай, бүрэн хэмжээгээр хариулах үүрэг хүлээнэ.

4. Хороо нь дээрхи хяналтанд хамрагдах тайлангийн хугацаанд өрнөсөн үйл явдлын талаар Барааны худалдааны зөвлөлд мэдээлнэ.

8 дугаар зүйл *Төгсгөлийн заалт*

Нөхцөлт тайлбар хийх

1. Энэхүү Хэлэлцээрийн аль нэг заалтад бусад гишүүний зөвшөөрөлгүйгээр нөхцөлт тайлбар хийхгүй.

Дотоодын хууль тогтоомж

2. (a) Гишүүн бүр ДХБ-ын тухай Хэлэлцээр түүний тухайд хүчин төгөлдөр болох өдрөөс оройтуулалгүйгээр дотоодын хууль тогтоомж, журам болон захиргааны процедурыг энэхүү Хэлэлцээрийн заалтад нийцүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

(b) Гишүүн бүр энэхүү Хэлэлцээрт холбогдох хууль тогтоомж, журам болон тэдгээрийн зохицуулалтанд гарсан аливаа өөрчлөлтийн талаар Хороонд мэдээлнэ.

⁷ 1947 оны ТХЕХ-ийн 1971 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн L/3515 тоот баримт бичгээр анх тараагдсан